

ДИЗЕЛЬ ГЕНЕРАТОРТ ТАВИГДАХ ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Ерөнхий

Энэ техникийн шаардлагад эрчим хүчний нөөц тэжээлийн цахилгаан үүсгүүр болох дизель генераторын шаардлагатай техникийн үзүүлэлтүүдийг тусгав.

Техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэгч нь 2 ширхэг иж бүрдэл бүхий дизель генераторыг нийлүүлнэ.

2. Техникийн шаардлага

- Дизель генераторын ажлын хүчдэл давтамж нь тоног төхөөрөмжийг ажиллуулах стандартанд тохирсон байх,
- Удирдлагын самбарын дэлгэц дээр гарах бүх мэдээлэл нь англи хэл дээр байх,
- Нийлүүлэгдэж байгаа тоног төхөөрөмж нь бэлэн бүтээгдэхүүн байх,
- Дагалдах зураг схемийн бүрдэлтэй байх,

Үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь олон улсын BS5000, ISO 8528G2-3, ISO 3046, IEC60034, NEMA MG-1.22 стандартуудын шаардлагуудыг хангасан, ISO буюу олон улсын чанарын удирдлагын системийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн гэрчилгээжсэн байх ба гэрчилгээний хуулбар хувийг нийлүүлэгч нь тендерийн материалд хавсаргасан байна.

3. Тоног төхөөрөмжийн бүрэлдэхүүн хэсгүүд

Нийлүүлэгдэх тоног төхөөрөмжүүд дараахи хэсгүүдээс бүрдэнэ.

1. Дизель генератор /FG. Wilson DE 110E2 брендийн дизель генератортой дүйцэхүйц/
2. Ачаалал шилжүүлэх самбар
3. Дагалдах сэлбэг

• Дизельгенераторын техникийн үзүүлэлт:



Нийлүүлэгдэх дизель генераторын техникийн үзүүлэлт нь FG. Wilson брендийн DE 110E2 маркийн дизель генераторын техникийн үзүүлэлттэй дүйцэхүйц байна.

• Генераторын техникийн үзүүлэлт			
№	Өгөгдөл	Нэгж	Тоо
1	Хүчин чадал	кВА	100
2	Давтамж	Герц	50
3	Хүчдэл (хувьсах 3 фаз)	Вольт	380-415

4	Эргэлтийн тоо	Эрг/мин	1500
5	Хүчдэлийн хэлбэлзэл	%	± 5
6	Чадлын коэффициент	cosφ	0,8
7	Генераторын төрөл	LL2014L	
8	Холхивчын тоо	1	
9	Хамгаалалтын зэрэг	IP23	
10	Хөндийрүүлгийн төрөл	H	
11	Өдөөлтийн систем	Шунт	
12	Удирдлагын самбарын төрөл	Power Wizard 1.1	
13	Модель АРН:	R250	

• **Хөдөлгүүрийн техникийн үзүүлэлт**

№	Өгөгдөл	Нэгж	Тоо
1	Цилиндрийн тоо		4
2	Эргэлтийн тоо	Эрг/мин	1500
3	Асаалтын систем	Вольт	12
4	Аккумулятор цэнэглэгч	Ком	1
5	Такт		4
6	Хөдөлгүүрийн төрөл	CAT C4.4	
7	Хөргөлтийн арга	Усан	
8	Регуляторын төрөл	Механик / Цахилгаан	
9	Тохируулгын ангилал	ISO 8528G2	
10	Түлшний шүүрийн төрөл	Солих элементтэй	
11	Агаарын шүүгчийн төрөл	Солих элементтэй	
12	Тосны шүүр	Эргэгдэж суурилагддаг	
	Тосны төрөл	API GG4 / CH4 15W-40	



Удирдлага нь:

- Хүчдэл, давтамж, мото цаг, ачаалал хянах,
- Автомат болон гар байдалд дизель генераторыг ажиллуулдаг байх,
- Усны температур, хөдөлгүүрийн эргэлт, маслын даралт, түлшний түвшин, аккумуляторын цэнэг зэргийг хянах,
- Удирдлагын самбарт тохиргоо хийх хянаж шалгах мэдээллийн сүлжээнд холбогдож ажиллагааг хянах боломжтой байх

Бусад

- Дизель генераторын түлшний үндсэн бак нь тухайн дизель генераторыг 10 цаг ажиллуулах түлш агуулдаг байх, нийлүүлэхдээ түлштэй байх
- Дизель генератор нь өөрийгөө халуун бэлтгэлтэй байлгах халаагчтай байх,
- Аккумулятор цэнэглэгч нь аккумуляторын төрөлдөө тохирсон байх,
- Халаагуурын хоолойг солиход хялбар болгож хаалтаар тоногдсон байх
- Түлшний систем нь гар болон цахилгаан насосоор тоноглогдсон байх

- **Ачаалал шилжүүлэх самбар:**

Ачаалал шилжүүлэх самбар (цаашид АШС гэнэ) төвийн болон генераторын хүчдэлийг

автоматаар шилжүүлэх үүрэг бүхий төхөөрөмж юм.

Тавигдах шаардлага:

- Төвийн хүчдэлийн 3-н фазийн дээд ба доод хязгаарыг хянах,
- Төвийн хүчдэлийн 3-н фазийн тасралтуудыг хянах,
- Шилжүүлэлтийн үед хүчдэл мөргөлдөхөөс бүрэн хамгаалагдсан байх,
- Төвийн болон генераторын хүчдэлээр дагнаж ажиллах боломжтой байх,
- Гүйдэл даах чадвар нь тухайн ачаалалд тохирсон байх,
- Механик болон цахилгаан (хориг) цоожтой байх,
- АШС-ыг ажиллагаанаас бүрэн чөлөөлөх "BYPASS" холбогчтой байна.
- АТІ 400 удирдлагын панельтай байх



- **Сэлбэг**

Дизель генераторт анхан шатны үзлэг үйлчилгээ хийхэд шаардлагатай сэлбэг хэрэгслийн иж бүрдэлтэй байна. /Түлшний шүүр, маслын шүүр, агаар шүүгч, сальникүүд/

6. Сургалт

Нийлүүлэгдэх дизель генератор болон АШС-ыг нийлүүлж, суурилуулсаны дараа захиалагч талын ашиглалтын инженер, техникийн ажилтнуудыг, тухайн дизель генераторын ашиглалт засвар үйлчилгээтэй холбоотой сургалтанд үйлдвэрлэсэн газар нь сургаж дадлагажуулна.

7. Техникийн баримт бичиг, гарын авлага

Нийлүүлэгдэх тоног төхөөрөмжүүдийн ажиллагаа болон ашиглалт, засвар үйлчилгээ, суурилуулалтын гарын авлага хавсаргагдсан байна. Гарын авлага болон ном, материалууд нь англи хэл болон монгол хэл орчуулагдсан байна.